

ГАРЧИГ

Гарчиг	1
нэг. Ерөнхий танилцуулга	2
1.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2
1.2. Төслийн танилцуулга.....	2
1.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй	5
хоёр. байгаль хамгаалах төлөвлөгөө.....	7
2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8
2.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	15
2.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	16
2.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө.....	18
2.5. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	19
2.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
2.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
гурав. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	29
3.1. Агаарын чанарын хяналт шинжилгээ	29
3.2. Гадаргын усны хяналт шинжилгээ.....	30
3.3. Газрын доорх усны хяналт шинжилгээ.....	31
3.4. Хөрсний хяналт шинжилгээ.....	32
3.5. Ургамлын хяналт шинжилгээ	33
дөрөв. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	37

НЭГ. ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

1.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төслийн талбайн орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОАЖЯ нь төслийн БОМТ-г батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох, жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянана. Мөн БОМТ-ний хэрэгжилтэд сумын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, Засаг дарга, БОАЖЯ болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй.

БОМТ-г 2014 онд БОНХ-ийн сайдын баталсан “Аргачлал батлах тухай” тушаал, мөн 2014 онд БОНХ-ийн сайдын баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” болон бусад холбогдох дүрэм журам, стандартад нийцүүлэн, БОННУ-ний судалгааны үр дүнд үндэслэн 3 жилээр төлөвлөн гүйцэтгэсэн болно. БОМТ нь доорх үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах үйл ажиллагааг тусгасан **байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө**
- Төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүх л хугацааны турш хэрэгжүүлэх **орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр**-өөс бүрдэнэ.

1.2. Төслийн танилцуулга

1.2.1. Төслийн нэр

Авдрантын цагаан тугалганы орд ашиглах

1.2.2. Төслийн зорилго

“Принципал инвестмэнтс” ХХК нь Авдрант уулын цагаан тугалганы шороон ордыг Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн үр ашигтайн зэрэгцээ байгаль орчинд ээлтэй байх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг чухалчлан улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, үйлдвэрлэлийн хаягдал багатай шинэ техник технологи, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шинэ дүрэм журам нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангахад энэхүү төслийн зорилго оршино.

1.2.3. Төсөл хэрэгжүүлэгч

“Принципал Инвестмэнтс” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011473111

Регистрийн дугаар: 5840716

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-020997

Хаяг: Хан-Уул дүүрэг, 15-р хороо, үйлдвэр 2 зайсан, 27 А-901



Холбоо барих: 976-88117224

1.2.4. Төслийн байршил

Ашиглалтын MV-020997 тусгай зөвшөөрлийн дугаар бүхий Авдрант уулын цагаан тугалганы орд нь Төв аймгийн Эрдэнэ сумын Хушинга багийн нутагт Улаанбаатар хотоос зүүн тийш 85 км, Эрдэнэ сумын төвөөс зүүн урагш 15 км зайд оршино.

Хүснэгт 1. Төслийн тусгай зөвшөөрлийн талбайн координат

Тусгай зөвшөөрлийн дугаар	Булангийн цэгийн солбицол			Талбайн хэмжээ, га
	№	Уртраг, E	Өргөрөг, N	
MV-020997	1	107° 59' 10.40"	47° 39' 30.50"	1,314.72 га
	2	107° 59' 10.40"	47° 39' 08.00"	
	3	107° 58' 26.70"	47° 39' 08.00"	
	4	107° 58' 26.70"	47° 38' 54.81"	
	5	107° 59' 10.40"	47° 38' 54.81"	
	6	107° 59' 10.40"	47° 38' 28.40"	
	7	107° 59' 35.70"	47° 38' 28.40"	
	8	107° 59' 35.70"	47° 38' 11.60"	
	9	108° 00' 01.48"	47° 38' 11.60"	
	10	108° 00' 01.49"	47° 37' 28.60"	
	11	107° 59' 36.00"	47° 37' 28.60"	
	12	107° 59' 36.00"	47° 37' 45.60"	
	13	107° 59' 07.12"	47° 37' 45.60"	
	14	107° 59' 07.12"	47° 38' 08.50"	
	15	107° 58' 40.72"	47° 38' 08.50"	
	16	107° 58' 40.72"	47° 38' 30.82"	
	17	107° 57' 38.80"	47° 38' 30.82"	
	18	107° 57' 38.80"	47° 37' 59.60"	
	19	107° 57' 06.50"	47° 37' 59.60"	
	20	107° 57' 06.50"	47° 37' 42.46"	
	21	107° 56' 34.63"	47° 37' 42.46"	
	22	107° 56' 34.63"	47° 38' 16.20"	
	23	107° 57' 11.70"	47° 38' 16.20"	
	24	107° 57' 11.70"	47° 38' 44.90"	
	25	107° 57' 36.30"	47° 38' 44.90"	
	26	107° 57' 36.30"	47° 39' 01.80"	
	27	107° 57' 11.70"	47° 39' 01.80"	
	28	107° 57' 11.70"	47° 39' 22.50"	
	29	107° 56' 41.43"	47° 39' 22.50"	
	30	107° 56' 41.43"	47° 40' 01.77"	
	31	107° 58' 11.42"	47° 40' 01.77"	
	32	107° 58' 11.42"	47° 40' 31.77"	
	33	108° 00' 01.50"	47° 40' 31.76"	
	34	108° 00' 01.50"	47° 39' 47.30"	
	35	107° 59' 35.70"	47° 39' 47.30"	
	36	107° 59' 35.70"	47° 39' 30.50"	



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил



Зураг 2. Төсөл хэрэгжих орчны фото зураг

1.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

“Авдрантын цагаан тугалганы ордыг ашиглах” төслийн 2023-2024 оны хооронд хэрэгжүүлэх БОМТ-ний нийт зардлыг **24,584.8** мян.төг буюу хорин дөрвөн сая таван зуун наян дөрвөн мянга найман зуун гучин хоёр төгрөг байхаар тооцоолов.

БОМТ-ний 2023 оны нийт зардал

	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал /төг/
Нэг. Байгаль хамгаалах төлөвлөгөө		
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	9,513,900
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	3,727,932
3	Дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө	5,100,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3,000,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,975,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,598,000
	Нийт зардал	24,913,932

ХОЁР. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль хамгаалах төлөвлөгөөг дараах хэсгүүдэд ангилан авч үзэв.

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө
5. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө
6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлсэн болно.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, 2023-2024 он

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<i>Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ</i>								
БО, ХАБЭА-тай холбоотой хууль, дүрэм журмын шаардлагыг бүрэн хангаагүйгээс эрх зүйн зөрчил бий болох, эрсдэл үүсэх	Уурхайн үйл ажиллагаа, онцлогт тохируулан ХАБЭА болон БО-ны бодлого дүрэм журмыг боловсруулан мөрдүүлэх	Төслийн хэмжээнд	-	-	-	-	2023	- Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
	Эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны холбогдолтой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх	Төслийн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардал			2023-2024	- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль - Газрын тухай хууль - Усны тухай хууль - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу экологийн паспорт хөглөх	Төслийн хэмжээнд	ш	13.9	1	13.9	2023	- “Журам батлах тухай” БОАЖ-ын сайдын 2019 оны А/618 дугаар тушаал /Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам/
	Осол аваар устгах төлөвлөгөө, гамшгаас хамгаалах төлөвлөгөө зэргийг дотооддоо боловсруулан батлах	Төслийн хэмжээнд	-	-	-	-	2023	
	Жил бүр БОМТ-г боловсруулан БОАЖА-аар батлуулж, хэрэгжүүлэх	Төслийн хэмжээнд			Тухайн жилийн БОМТ-ний зардал		Жил бүр	

	Газрын төлөв байдлын улсын чанарын хянан баталгааг тогтоосон хугацаанд хийлгэх	Уурхайн ашиглалтын ба эдэлбэр газар	удаа	Үйл ажиллагааны зардлаар			2023	- Байгаль орчны хамгаалал. Аж ахуйн нэгжийн экологийн паспорт. Үндсэн дүрэм. MNS 4219:1994
	Байгаль орчны аудитыг тогтоосон хугацаанд хийлгэх	Төслийн хэмжээнд	удаа	2022 онд үйл ажиллагаа явагдаагүй учир БОА-ыг 2024 онд хийлгэнэ.			2024	
	Жил бүр газар, ус ашигласны болон байгаль орчинтой холбогдолтой бусад төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх	Төслийн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардал			Жил бүр	
Агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ								
Хөрс хуулах, элс олборлох, ачиж тээвэрлэх, буулгах, овоолго байгуулах үед сул шороо болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоос шороо дэгдэх	Хуурайшилт ихтэй, салхи, шуурга ихтэй үед зам талбайг чийгшүүлэх, услах	Зам, карьер, ажиллагсдын суурин	-	Үйл ажиллагааны зардалд тусгах			2023	- Агаарын тухай хууль. - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Хог хаягдлын тухай хууль. - Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4585:2016 - Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5885:2008
	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдыг тогтоож мөрдүүлэх, тэмдэг, тэмдэглэгээ байршуулах	Тээврийн хэрэгслүүд, зам, карьер, ажиллагсдын суурин, засварын газар	ш	25.0	10	250.0	2023	
	Машин техникийн зорчих маршрутыг тогтоож мөрдүүлэх			Үйл ажиллагааны зардал			2022	
	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, ногоон зурвас үүсгэх	Зам дагуу, ажиллагсдын суурин орчимд	га	3.5	1000	3500.0	Жил бүр	
Хүнд даацын машин техник, уурхайн ажилчдын хэрэгцээнд ашиглаж буй автомашины хөдөлгүүрээс ялгарах хорт хий агаарын чанарт нөлөөлөх	Тээврийн хэрэгслүүдэд оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Бүх тээврийн хэрэгсэл	-	Үйл ажиллагааны зардал			Жил бүр	
	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу агаарын чанарын мониторинг хийх, дотоод хяналт явуулах,	Төслийн хэмжээнд		Үйл ажиллагааны зардал			Жил бүр	

Ахуйн хог хаягдлыг зориулалтын бус талбайд, ил задгай удаан хадгалснаас орчин бохирдох, таагүй үнэр гарах	Ахуйн хог хаягдлыг дахин ашиглах, ашиглахгүйгээр нь ангилан ялгаж, дахин ашиглагдахгүй хог хаягдлыг зөөвөрлөх, зайлуулах, устгах арга хэмжээ авах, дахин ашиглах хог хаягдлыг эргүүлэн ашиглах эсхүл дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Ажиллагсдын суурин	-	Үйл ажиллагааны зардал			тогтмол	
	Хог хаягдал хадгалах түр цэгт ариутгал, халдваргүйжүүлэлт хийх, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах	Хог хаягдлын цэг	удаа	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардалд тооцож оруулав			Улирал бүр	
	Хог хаягдлыг ил задгай шатаахгүй байх, хуванцар, нийлэг материал шатаахгүй байх	Хог хаягдлын цэг, ажиллагсдын суурин	-	-	-	-	тогтмол	
Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ								
Уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас газрын гадарга эвдрэх, орчны ландшафтын төрх өөрчлөгдөх	Хөрс хуулалт болон овоолгод өртөх талбайн үржил шимт хөрсийг тусад нь байршуулж, стандартын дагуу хадгалах, нөхөн сэргээлтэд ашиглах	Карьер, овоолго, зам		Үйл ажиллагааны зардал			2023-2027	- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль - Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт. MNS 5915:2008. - Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5916:2008.
	Ашиглалт явуулж дууссан талбайд дотоод овоолго, нөхөн дүүргэлт, хэвгийжүүлэлтийн ажил хийх	Карьер		Нөхөн сэргээлтийн зардалд тооцож оруулав.			2023-2024	
Хүнд даацын машин техникийн хөдөлгөөнөөр олон	Төслийн талбайн хэмжээнд замын тогтсон маршрут тогтоож, түүнийг салаалах,	Зам	ш	50.0	10	<u>500.0</u>	2023	

салаа зам гарах, хөрс, ургамал талхлагдах, газар эвдрэлд орох	өргөсөхөөс хамгаалан замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээ хийх, зам засах, сайжруулах ажлыг тогтмол хийж байх							- Замын тэмдгүүд, ерөнхий техникийн шаардлага. MNS 4597:1998 - MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. - MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
	Ажиллагсдын суурин болон бусад хүний хөл хөдөлгөөн ихтэй газрыг хайрган хучаасаар хучих	Ажиллагсдын суурин, бусад	-	500.0	-	500.0	2023	
Авто засварын газрын техникийн тос тосолгооны материал асгарснаас хөрс бохирдох	Түлш, шатах тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих, асгаралт үүссэн талбайг цэвэрлэх, хөрсийг саармагжуулах арга хэмжээ авч ажиллах		-	Үйл ажиллагааны зардал			Тухай бүр	
	Засварын газар болон авто зогсоолыг хатуу хучилттай болгох	Засварын газар, зогсоол	га	1,500.0	1	1500.0	2023	
Шаардлага хангахгүй нүхэн жорлон ашигласнаар хөрс бохирдох, улмаар газрын доорх ус бохирдох	Бага оврын бохир ус цэвэрлэх байгууламж судалж, суурилуулах	Ажиллагсдын суурин	ш	Үйл ажиллагааны зардал			2023	
Гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ								
Элс угаан баяжуулаад шаардагдах сэлбэлтийн усыг гүний худгаас татаж ашиглах учир газрын доорх усны нөөцөд нөлөөлөх	Газрын доорх усны нөөц тогтоох нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Усан орчин	-	Үйл ажиллагааны зардал			2023	- Усны тухай хууль - Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм
	Газрын доорх усны хяналт-мониторингийн цооног өрөмдөх	Усан орчин	-	Үйл ажиллагааны зардал			2023	

	Ус авах цэг, худаг, шугам хоолой бүрийг тоолууржуулах	Гүний худаг, усны шугам	ш	625.0	1	625.0	2023	<ul style="list-style-type: none"> - Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам - Усан мандал. Газар доорх усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага. MNS 3342:1982 - Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 6148:2010 - Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 0900:2018 - Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага. MNS 4943:2015
	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах	Усан орчин	-	-	-	-	тогтмол	
	Ус ашглалтын тайлан мэдээ хөтлөх, холбогдох төрийн байгууллагад хүргүүлж байх	Усан орчин	-	-	-	-	Жил бүр	
Ахуйн бохир усны цооног хальж ойр орчмын хөрс, улмаар бага гүний усыг бохирдуулах	Гүний худгуудыг гадны нөлөө, бохирдлоос хамгаалах үүднээс тохижуулалт хийж, хашаа, байшин барих	Гүний худаг	ш	1,125.0	1	1,125.0	2023	
	Дунд оврын ус цэвэрлэх байгууламж суурилуулах. Ингэснээр бохир ус татан зайлуулах зардал байхгүй болж, дэвшилтэт технологи ашиглан усыг хоёрдогч хэрэглээнд ашиглах	Ажиллагсдын суурин	ш	Үйл ажиллагааны зардал			2023	
	Улирал бүр ундны усны эх үүсвэрээс дээж аван итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх	Гүний худаг	ш	ОХШХ-ийн зардалд тусгасан.			Улирал бүр	
	Эргэлтийн усны нуурыг хамгаалан далан хийх, уурхайн талбайд мөн үерийн уснаас хамгаалах далан, суваг, шуудуу хийх	Тунаах нуур, уурхайн талбай, ажиллагсдын суурин	-	Үйл ажиллагааны зардал			2023	

Ургамлын аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ								
Уурхайн олборлолт, овоолго, зам, барилга байгууламжийн талбайн ургамал бүрхэвч дарагдах, талхлагдах	Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу үүсгэх, хадгалах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах			Үйл ажиллагааны зардал				- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт. MNS 5915:2008 - Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн шаардлага. MNS 5918:2008
	Биологийн нөхөн сэргээлтийн туршилт судалгааны талбайг одооноос бий болгох хэрэгтэй бөгөөд нөхөн сэргээлтэд ашиглах олон наст өвслөг ургамал болон мод, сөөг, сөөгөнцөр ургамлыг тарьж ургуулах туршилт судалгааны ажлыг хийж үр дүнтэй ургасан ургамлыг нөхөн сэргээлтэд ашиглах			Үйл ажиллагааны зардал				
Төслийн талбайд ашиглагдаж байгаа техник хэрэгслийн хөдөлгөөний улмаас тухайн орчинд шинэ зам бий болох, тухайн орчны ургамлан нөмрөг талхлагдах сийрэгшэх	Ашиглалт явуулж дууссан талбайд дотоод овоолго, нөхөн дүүргэлт, хэвгийжүүлэлтийн ажил хийх							
	Хөрсний элэгдэл, эвдрэлийг хязгаарлах үүднээс мод тарих, ногоон зурвас үүсгэх	Зам дагуу, ажиллагсдын суурин орчимд	га	4.5	1000	<u>4500.0</u>	Жил бүр	
	Ургамлын мониторинг, судалгаа шинжилгээ хийх	Төслийн талбай	-	ОХШХ-ийн зардалд тусгасан.			Жил бүр	
Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ								

Уурхайн лицензийн эвдрэлд өртөх талбайн зарим хэсэгт амьдарч байсан сээр нуруугүй болон сээр нуруутан амьтад үгүй болж, гүйдлийн махчин болон туруутан амьтны гүйдлийн зам хаагдах, ус намгийн нүүдлийн шувуу бууж амрах, хооллох талбай зэрэг хумигдах сөрөг нөлөөтэй	Өвс тэжээл нөөцлөн өвөл, хаврын улиралд тавьж өгөх, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Төслийн талбайн ойр орчим	удаа	1,500.0	1	1,500.0	2023	- Амьтны тухай хууль - БОНБУ тухай хууль
Ил задгай нүх, тунаах нууранд амьтан унаж, осолдох	Амьтан унаж осолдохоос хамгаалах хашаа хамгаалалт барих	Лицензийн хүрээ	-	Үйл ажиллагааны зардал			2023	
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал 9,513.9 мян.төг								

2.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө


Төслийн нөхөн сэргээлт хийх аргачлал болон нөхөн сэргээлтийн ажлын зардлыг БОНХАЖ-ын Сайдын 2015 оны А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-д заасны дагуу тооцов. 2023 онд ашиглалт явуулж эхлэх учир биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй, 2 га талбайд дотоод овоолго буюу техникийн нөхөн сэргээлт хийгдэнэ.

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, 2023 он

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Техникийн нөхөн сэргээлт	Ашиглалт явуулж дууссан талбайд дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийж, хэлбэршүүлэлт, нягтруулалт хийнэ.	га	2,3	1,620.84	3,727.9	Олборлолтын үйл ажиллагаатай зэрэгцүүлэн хийнэ.	-MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт -MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага -MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн шаардлага -“Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал” (БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-138 дугаар тушаал)
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зардал – 3,727.932 мян.төг							

2.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Төсөл хэрэгжиж буй Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт дүйцүүлэн хамгаалах хэрэгжүүлэх боломжтой газар нутгийг төслийн талбайгаас зүүн тийш 39.1км зайд орших “Дэлгэрхаан уул”, баруун урагш 53.1км зайд орших “Дөлгөөн уул”-нд сонгох боломжтой байна.



Зураг 3. Дүйцүүлэн хамгаалал хийх боломжтой газар нутгийн байршил

Төсөл хэрэгжүүлэгч нь дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх газрыг сонгохдоо нутгийн иргэд, мэргэжлийн байгууллага, аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн зэрэг бусад оролцогч талуудын саналыг авсан байна. Түүнчлэн:

- Ижил төстэй экосистем байх;
- Орон зайн хувьд ойр байх;
- Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай газруудын жагсаалтад орсон байх;
- Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээнд нутгийн иргэдийн оролцоог хангах үүднээс тухайн нутгийн иргэдийн хамтран ажиллах сонирхол, идэвх санаачилга, малчдын зохион байгуулалтын хэлбэр зэргийг харгалзаж үзнэ.

Одоогоор дүйцүүлэн хамгаалал хийх газрын байршлыг орон нутагтай тохироогүй байгаа тул газрын байршлыг эцэслэн тогтоогоогүй байна. Иймд орон нутагтай харилцан тохирч, иргэдийн саналыг авсны үндсэн дээр дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.


Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 2023 он

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төслийн зайлсхийх боломжгүй сөрөг нөлөөллийг бууруулах үүднээс экосистемийн ижил нөхцөл бүхий газар нутгийн биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, орчны экосистемийг сайжруулах	Дүйцүүлэн хамгаалах газарт биологийн олон янз байдлын суурь судалгаа хийлгэж, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөл боловсруулах /орон нутгийн болон мэргэжлийн байгууллагатай хамтрах/	Төсөл хэрэгжиж буй газар нутагтай ижил экосистем бүхий газар нутаг	1	1,600	1,600.0	2023	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль - Усны тухай хууль - Амьтны тухай хууль
	Булаг шандны эхийг тохижуулах, нөхөн сэргээх, хамгаалах		-	-	1,000.0	2023	
	Зэрлэг амьтдын амьдардаг багийн удирдлага, иргэдтэй зөвшилцөн сонгосон газарт биотехникийн үйл ажиллагаа явуулах		-	-	1,500.0	2023	
	Орон нутгийн болон улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын хамгаалалтын чадавх, менежментийг сайжруулах зорилгоор санхүүгийн туслалцаа үзүүлэх		-	-	1,000.0	2023	
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал – 5,100.0 мян.төг							

2.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн 41.1-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна.” гэж заасан.

Тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчмын айл өрх болон тэдгээрийн өвөлжөө хаваржааны байршлыг тогтоох зорилгоор радиус татаж үзэхэд тусгай зөвшөөрлийн талбай дотор 3 айл, 500м-ийн радиус дотор 1 айл, 1000м-ийн радиус дотор 2 айл, 2500м-ийн радиус дотор 3 айл, 5000м-ийн радиус дотор 7 айл өрхийн өвөлжөө хаваржаа багтаж байна.



Зураг 1. Төслийн талбайн ойр орчим дахь айл, өвөлжөө хаваржааны байршил

Авдрантын ордыг ашиглах явцад үүсэх дуу шуугиан, тоосжилт, газрын гадаргын эвдрэл зэрэг нь малчин иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй малын бэлчээрийн талбайг багасгах сөрөг нөлөөтэй.

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлж буй нөлөөлөл тус айл өрхийн гишүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулах, малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа нь хяналт шинжилгээний хөтөлбөр болон бусад холбогдох баримтуудаар тогтоогдвол төсөл хэрэгжүүлэгч “Принципал инвестмэнтс” ХХК нөлөөлөлд өртөх эрсдэлтэй малчин өрх, Эрдэнэ сумын удирдлагатай хамтран нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө 2023 он

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Төсөл хэрэгжих АМТЗ-ийн талбайн ойр, орчим болон нөлөөллийн бүсэд нутаглаж амьдардаг иргэд	Шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	Уурхайн нөлөөлөлд өртсөн, нүүлгэн шилжүүлэх айл өрхийн хэмжээгээр		Харилцан тохиролцоо замаар	2023 он	“Ашигт малтмалын тухай” хуулийн 41 дүгээр зүйл

2.5. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төслийн лицензийн талбай дотор одоогийн байдлаар газар дээр ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй. Цаашид төсөл хэрэгжүүлэх явцад газар доор ямар нэгэн түүх соёлын дурсгал илэрсэн тохиолдолд тухайн төслийн үйл ажиллагааг түр зогсоож Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу ГТГ, ШУА-ийн Археологийн хүрээлэнд урьдчилан мэдэгдэж, мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах, малтлага судалгааны ажлыг хийлгэж, холбогдох байгууллагаас зохих зөвшөөрөл авсны дараа үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах шаардлагатай.

Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө 2023 он

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Орд орчим байж болзошгүй түүх соёлын өвүүд	Шаардлагатай тохиолдолд авран хамгаалах арга хэмжээ зохион байгуулах	Судалгаагаар түүх соёлын биет өв илэрвэл тухайн олдворын хүрээнд		Үйл ажиллагааны зардлаар	2023 он	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

2.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Осол эрсдэлээс хамгаалах ажлын дийлэнх нь төсөл хэрэгжих явцад компаний удирдлага болон ажиллагсадын хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд цаг уурын эрсдэлтэй нөхцлөөс үүсэх гэнэтийн осол урьдчилан сэргийлэх ажилд холбогдох зардал нь төслийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой юм.

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, 2023 он

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. Байгалийн гамшигт үзэгдлээс үүсч болзошгүй осол эрсдэл				
Эрчимтэй орсон хур тунадасны нөлөөгөөр гэнэтийн үер үүсэх, улмаар уурхайн карьер усанд автах, үүнээс шалтгаалан уурхайн хэвийн үйл ажиллагаа зогсох, дэд бүтэц, барилга байгууламж үерт автан эвдэрч сүйдэх, карьерын хана, далан нурах, уурхайн эдэлбэр орчмын хөрс элэгдэх, хүний амь нас эрсдэж болзошгүй. Хүчтэй үер нь хөрсний нуралт, гулсалтыг үүсгэх магадлалтай.	Уурхайн ашиглалтын жилээс хамааруулан тухайн хугацаанд үерийн тооцоо хийсэн байршлуудад сайраар орж ирэх усыг зайлуулах суваг, шуудуу татах	Үйл ажиллагааны зардал	2023	
	Ус тунаах болон цэвэршүүлэх далангийн усны түвшнийг тогтмол хянах	Компаний бодлогын түвшинд зохицуулах	2023-2027 Тогтмол	
	Үер усны улмаас далан сэтгэсэн тохиолдолд уурхайн Аваар устгах дотоод төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авч цэвэрлэх.	Үйл ажиллагааны зардал	2023-2027 Тухай бүр	
Төслийн талбай нь газар чичирхийллийн мужлалаар 8 баллын бүсэд буюу хүчтэй газар хөдлөл болох магадлалтай бүсэд багтдаг. Газар хөдлөлтийн улмаас уурхайн хана, овоолго нурах, дэд бүтцийн барилга байгууламж эвдэрч сүйдэх, хүний амь нас, эрүүл мэнд эрсдэх аюултай.	Газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх,	Компаний бодлогын түвшинд зохицуулах	2023-2027	
	Аюулын үед барилга, байшингаас гарах гарцыг тэмдэгжүүлэх,	0.5	2023	
	Ажилчдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чадварыг эзэмшүүлэх	Компаний бодлогын түвшинд зохицуулах	2023-2027 Жил бүр	
Түр зуурын аадар бороог аянга цахилгаан, мөндөр дагалдах нь олонтаа. Аадар борооны үеийн аянга цахилгаанд хүн эрсдэж болзошгүй.	Талбай орчмын өндөрлөг газар болон цахилгааны дэд өртөө орчимд газардуулагч болон аянга зайлуулагч байрлуулах	0.5	2023	
Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гарах	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах	Компаний бодлогын	2023	

		түвшинд зохицуулах		
2. Үйл ажиллагааны буюу ил уурхай, баяжуулах үйлдвэр, хүний буруутай үйлдлээс үүсч болзошгүй осол, аюул				
Карьерийн догол үүсгэх аюулгүй байдлыг хангаагүйн улмаас осол аваар гарах	Ил уурхайд явагдах үндсэн ажлуудыг зохих шаардлагад нийцүүлэх асуудлын хүрээнд Үйлдвэр, худалдааны сайдын 2003 оны 98 дугаар тушаалын хавсралтаар баталсан ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрмийг баримталж ажиллах	Компаний бодлогын түвшинд зохицуулах	2023 Тогтмол	
Техник тоног төхөөрөмжийн осол аваар гарснаар хүний эрүүл мэнд, амь нас эрсдэх, техник хэрэгсэл эвдрэх, гэмтэх	Тоног төхөөрөмж бүр технологийн горимд нийцсэн буюу уг үйлдвэрлэлийн зориулалттай, ашиглалтын заавар, паспорттай байх, хяналт хэмжилтийн багажууд нь улсын стандартчилал, хэмжил зүйн албаар заавал баталгаажуулагдсан байх, аливаа засвар үйлчилгээ хийхэд тохиромжтой байрлал нөхцөлөөр хангагдсан байх	Компаний бодлогын түвшинд зохицуулах	Тогтмол хэрэгжүүлэх	
	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангах	1.5	2023	
	Ажлын байранд эмнэлгийн анхны тусламж эмийн сантай байх	0.5	2023	
Ажилчдын хайхрамж болгоомжгүйн улмаас гал алдах, гал түймэр гарч байгаль орчин сүйдэх, хүний эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх	Уурхайн нутаг дэвсгэрт гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгаа, хяналтын ажил, гал гарсан үед түүнийг унтраах хэрэгслийн хангамж, галтай харьцах ажил гүйцэтгэх, цахилгаан тоног төхөөрөмж дээр ажиллах үед мөрдөх аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг Галын аюулгүй байдлын тухай хууль, Аж ахуйн нэгж байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм, галын аюулгүй байдалтай холбогдуулан гаргасан бусад хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулах,	Компаний бодлогын түвшинд зохицуулах	2023	
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 1 жилийн нийт зардал – 3. сая.төг				

2.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдал нь ахуйн болон технологийн үйл ажиллагаанаас үүсэх ба хатуу, шингэн гэж ангилж болно.


Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, 2023 он

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдал	Ажилчдын хотхоноос гарч буй хог хаягдлыг галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн зориулалтын савнуудад ангилан ялгаж, хадгалах	Ахуйн хэрэглээ, ажиллагсдын кемп, хог хаягдал түр хадгалах цэг	ш	500.0	1	500.0	2023	<ul style="list-style-type: none"> - Хог хаягдлын тухай хууль - Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага - Ахуйн хог хаягдлын тээвэрлэлт. Ангилал. Ерөнхий шаардлага. MNS 5344:2011
	Хог хаягдлын цэгийн орчимд ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хугацаатай хийж байх		удаа	100.0	2	200.0	Улирал бүр	
	Орон нутагтай байгуулсан хог хаягдлын гэрээ байгуулах, тогтмол хугацаанд зөвшөөрөгдсөн цэгт ачиж зайлуулж байх		-	100.0	4	400.0	2023	
	Дахивар хог хаягдал буюу дахин ашиглах, боловсруулах боломжтой хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлэх		-	-	-	500.0	2023	
	Ногоо жимс, хүнсний үлдэгдэл хаягдлыг бордоо болгож ашиглах		-	-	-	375.0	2023	

Шингэн хаягдал	Бага оврын цэвэрлэх байгууламжийн судалгаа хийж, үйл ажиллагаандаа ашиглах	Ахуйн бохир ус	ш	Үйл ажиллагааны зардалд тусгах	1	Үйл ажиллагааны зардалд тусгах	2023	
	Цэвэрлэх байгууламжийн хаягдал усыг “MNS 6734-2018. Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага” стандартад нийцүүлэн цэвэрлэх. Цэвэрлэсэн усыг замын тоос дарах, машин угаах зэрэгт ашиглах		-	-	-	-	2023	
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний 1 жилийн нийт зардал – 1,975.0 сая.төг								

Тэрбум мод үндэсний хөдөлгөөн

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн талбайд 5000 ширхэг мод тарьна. 2023 онд 1000 ширхэг, 2024 онд 1000 ширхэг, 2025 онд 1000 ширхэг, 2026 онд 1000, 2027 онд 1000 мод сөөг тарьна.



Зураг 1. Мод тарих заавар

Тарималжуулалтын ажлын технологийн зөвлөмж.

- Төслийн талбайн хөрс ургамлыг элэгдэл эвдрэлээс хамгаалах, ногоон байгууламж байгуулах талаар дор дурдсан зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид зөвлөж байна. Үүнд:

- Барилга объектын талбайгаас бусад сул газрыг бүрэн хэмжээнд зүлэг ургах нөхцөлөөр бүрэн хангах, ургамалжуулах, тариалсан ургамлыг тухай бүр нь арчилж тордох арга хэмжээ авч хэрэгжүүлж байх;

Тарималжуулалтыг тайлангийн зөвлөмжид заасан технологийн горимын дагуу явуулах шаардлагатай ба мэргэжлийн байгууллагаас технологийн нэмэлт заавар, зөвлөгөө авч хэрэгжүүлэх

Зүлэг тарих товч заавар:

Тарих талбайн хөрсийг 20 см гүн байхаар тооцож бэлдэх / Чулуу, хог хаягдалгүй байх чулуурхаг хатуу хэсгийг ухаж авч хаян оронд нь органик бордоогоор бордсон хөрс хийх /Талбайг тэгшилж үрийг тарихаас өмнөх 10 см гүнд нэвтэрхээр услах. Үрийг гараар жигд цацаж тараах /1 м.кв-д 40 гр нормтой /0,5 -1 см зузаантай элсээр жигд хучих. Үрийг тарьсны дараагаар 5 см гүнд нэвтэрхээр услах. Цаашид өглөө оройд байнга услах 6, 7 саруудад зориулалтын машинаар тайралт хийх /өтгөн ургуулах зорилготой/ Өвөл буюу тарьснаас хойш бүхий л хугацаанд гишгэж талхлахгүй байх. Сонгосон талбайгаас хамаарч төсвийг байгууллага тусд нь гаргаж өөрийн нөхцөл бололцоонд тулгуурлан хэрэгжүүлэх ба хугацааг өөр өөрийн боломжоор тогтоох.

Тарималжуулалтад зориулж мод сөөгийг сонгон авах, суулгахад бэлтгэх

Ногоон байгууламж байгуулах нь зарим төрлийн хорт хийн хэмжээг эрс багасгах нөхцөлийг бий болгодог. Судалгаанаас үзэхэд шилмүүст мод хүхэрлэг хийг илүү шингээх чадвартай ба түүний агаар дахь агууламжийг 2 дахин багасгадаг байна. Цэцэрлэгжүүлэлтэд зориулж мод, сөөг, ургамлыг ойгоос болон мод үржүүлгийн газраас шилжүүлэн суулгахдаа юуны өмнө авах модоо сайн шинжиж судлах шаардлагатай (*Геоэкологийн хүрээлэн, Мод тарих, ногоон байгууламж байгуулах нь, УБ 2005*).

Мод тарих хялбаршуулсан арга

1. Модыг хавар дөрөвдүгээр сарын 25-наас, тавдугаар сарын 25 хүртэлх хугацаанд тарих нь хамгийн үр дүнтэй байдаг ажээ.
2. Өөрийн сонгож авсан газраа 50-60 сантиметрийн гүн, 70-80 сантиметрийн өргөнтэй ухаж бэлтгэнэ.

3. Ухаж бэлтгэсэн нүхэндээ 50 хувь хар шороо, 30 хувь элс, 20 хувь хөх бууц болон бусад бордоог хийнэ.
4. Суулгацыг тарихдаа бэлтгэсэн нүхнийхээ голд үндсийг нь нугалалгүйгээр жигд тарааж, суулгаж өгнө.
5. Суулгасныхаа дараа хөрсийг сайтар нягтаршуулж, гишгэж өгөөд нэг модыг 40-60 литр усаар усална.
6. Өглөө оройн цагт 30-40 литр усаар нэг модыг нэгээс хоёр удаа услах бөгөөд, услах хоног нь долоогоос арав хоног. Суулгаснаас хойш арван сард нэг удаа цэнэг усалгааг хийх бөгөөд усалгаа хийх явцдаа хөрсний сийрүүлэлтийг хийж өгдөг байна.
7. Модоо тарьсан цагаас хойш гурван жилийн дараагаас арчилгаа усалгааг хийх шаардлагагүй болдог ажээ.
8. Мод сөөг тарьсны дараа талбайгаа зүлэгжүүлэхийн өмнө мод сөөгний нүхнээс гарсан хайрга, чулууг зөөж цэвэрлээд, шим тэжээл муутай газрын хөрсийг 20-30 сантиметр гүн хагалж хайрга чулууг цэвэрлэж аваад үлдсэн шороог зөөсний дараа хүрэн хөрсийг 2.5x2.5 сантиметрийн гишгүүрээр гишгиж, ургамлын үндэс болон бусад хогноос цэвэрлэж, гишгэсэн хар хүрэн хөрсийг 20 сантиметрээс доошгүй зузаан дэвсэж гадаргууд жигд тарааж тэгшилснээр зүлэг тарих талбай бэлэн болно. Үрийг нэг метр квадрат талбайд 50-80 грамм орохоор тооцоолж салхи багатай тогтуун өдөр талбайд жигд цацаад тармуураар самнасны дараа элсээр нэгээс хоёр сантиметр зузаан хучина.
9. Үүний дараа 50-100 килограмм жинтэй булаар булдаж зөөлөн шүршиж услана. Зүлэгжүүлэх ажлыг мод сөөг тарьсны дараа тавдугаар сарын хоёрдугаар хагасаас долдугаар сарын 10-нд багтааж тарьдаг байна. Тарьсан үрээ соёолтол хөрсийг нь чийгтэй байлгахын тулд өдөр бүр өглөө оройн сэрүүнд нэг метр квадрат талбайд 30-40 литр ус, үр соёолсноос хойш нэг метр квадрат талбайд 20-30 литр ус орохоор бодож долоо хоногт гурваас дөрвөн удаа услах бөгөөд гандуу үед өдөр бүр услах хэрэгтэй байдаг.

Модны нүх ухаж бэлтгэх

1. Цэцэрлэгжилт хийх талбайд шилмүүст /гацуур, нарс, шинэс/ модны нүхийг ухаж бэлтгэхдээ уулнаас ул хөрстэй байдгийг харгалзан нүхний хэмжээг 0.8-1.0 метрийн голчтой, 0.7-0.8 метрийн гүнтэй нүхийг ухаж бэлтгэнэ. Ухсан нүхнээс гарсан хөрс, шорооны байдлыг харгалзан нүхний 75 хувьд нь үржил шимт хар шороон хөрс, хөх бууц 10 орчим кг-ыг нэмж хийн сайтар хутгаж тэгшилж орхино.

2. Ухсан нүхнээс гарсан үржил шимгүй буюу хайргыг зөөж зайлуулан оронд нь хар шороон хөрснөөс бэлтгэн тавина. Энэ нь мод суулгах үед нэмэлт болон чигжихэд хэрэглэгдэнэ. Хуучин шороог болж өгвөл хэрэглэхгүй байх нь чухал. Учир нь хуучин бохир, үржил шимгүй, бүтцээ алдсан шороо, хөрсний үүрэг гүйцэтгэж шинэ суулгацны их, бага ямар нэг хэмжээгээр таслагдсан үндсийг цааш ургаж төлжихөд хангалттай шим тэжээл өгч чаддаггүй. Харин нарсны суулгац суулгах нүхэнд хар шороо 40 хувь, элс 60 хувь байхаар бодож сайтар хутган хольж бэлтгэнэ. Нарс ихэвчлэн элсэн болон хөнгөн хөрсөнд ургадаг онцлогтой. Модны нүх ухсан газар нь хөрсний сүврэлт ихтэй /ус барих чадваргүй бүтэцтэй/ бол нүхний ёроолыг шар шавраар өнгөцхөн шавардаж өгч болох ба үндсэн хөрсийг бүрэн солих шаардлагатай.

Навчит модны нүх ухаж бэлтгэх

Цэцэрлэгжилтэнд таригдах навчит модны нүхийг ухаж бэлтгэхдээ шилмүүст модны нүхнээс арай бага хэмжээтэй байна. Улиас суулгах нүхийг 0.5-0.6м гүн, 0.5-0.8 м голчтой ухаж бэлтгэнэ. Ухсан нүхэнд хар шороон хөрс бордооны холимгыг нүхний 75 хувьд нь болохуйц хэмжээгээр голд нь шовгор байдлаар хийж бэлтгэнэ. Улиангар, хус нь уулнаас ул хөрстэй ирэх боловч дээрх хэмжээнд /нүхэнд/ төдийлөн харшлахгүй юм.

Бут сөөгний нүх ухаж бэлтгэх

1. Цэцэрлэгжилтэнд таригдах төрөл бүрийн бут сөөгний нүх 50-60 см гүн, 40-50 см голчтой байна. Нүхэнд хийх шороо шим тэжээл сайтай хар шороон хөрс байх ба ухсан нүхнээс гарсан шороог ашиглаж болохоор бол /чулуу хайргагүй эсвэл хэт их шаварлаг юмуу дангаараа элс биш/ түүн дээр 2-4 кг хөх бууц, 75-100 гр фосфорын бордоо нэмж сайтар хольж хийнэ.
2. Ургамлан хашлага тарих шуудуу нь 50 см өргөн, 50 см гүнтэй байна. Шуудуунд хийх шорооны хэмжээ шуудууны 75 хувьтай тэнцэх хэмжээнд байна. Ухсан шуудуунаас гарсан шороог ашиглах боломжтой бол хар шороо, бууц, эрдэс бордоог дээрх хэмжээгээр хольж сайжруулсан хэлбэрээр ашиглаж болохоос гадна дан хар шороог ашиглаж болно.

3. Ер нь олон жил талхлагдаж хөрсний үржил шим бүхий давхарга байхгүй болсон, хог болон бусад зүйлээр их бага ямар нэг хэмжээгээр бохирдсон байдаг учир шинээр хийх тохижилт, цэцэрлэгжилтэнд хуучин хөрсийг ашиглахгүй байх нь зүйтэй юм.
4. Мод бут сөөгний нүх ухаж бэлтгэх явцад хөрсний бүрэн шинжилгээ хийлгэчихвэл цаашид ногоон байгууламжаа өргөтгөх, услах, бордох, ямар ургамал таривал зохих талаар өргөн мэдлэгтэй болно.
5. Харин бөөрөлзгөнө тарихаар сонгосон талбайн хөрсний гүний ус 1.5 метрийн гүнд тархсан, хучиж өвөлжүүлэхэд тохиромжтой хөнгөн бүтэцтэй байх нь чухал юм.
6. Бөөрөлзгөнө үндсээрээ мөлхөж ургадаг тул хоёр бутны хоорондох зайг 3 метрээс багагүй байхаар бодож талбайг бэлтгэх хэрэгтэй. Бөөрөлзгөнийг шуудуунд тарих нь илүү тохиромжтой бөгөөд 35-40 см гүн, 50-70 см өргөнтэй шуудуу ухаж бэлтгэнэ.
7. Нэгэнт бэлтгэж бэлэн болгосон нүх, шуудуугаа тарилт хийхийн урд өдөр 1-2 удаагийн давтамжаар ханатал нь усалж өгнө. Энэ нь хөрсний чийг багтаамшилтанд их тустай.


ГУРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь “Цагаан тугалганы ордыг ашиглах” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор агаар, хөрс, гадаргын болон газрын доорх ус, ургамал, амьтаны нөхцөл байдалд ажиглалт явуулах, хяналт шинжилгээ хийх үйл ажиллагааны удирдамж болно. Уг ОХШХ-ийг төлөвлөхдөө хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд, тэдгээрийн байршил, дээж авах хугацаа, давтамж, хяналт шинжилгээ хийх аргачлал, стандарт, нийт зардал зэргийг бүхэлд тусгасан БОННУ-ний нэг чухал баримт бичиг юм.

Хяналт шинжилгээ хийхэд анхаарах зүйлсийг байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр доор оруулав.

3.1. Агаарын чанарын хяналт шинжилгээ

Төсөл хэрэгжих явцад агаарын чанарт хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүдийг хүснэгтэд харуулсан ба эдгээрээс хамгийн их сөрөг нөлөөтэй үзүүлэлт нь суллагдсан хөрснөөс дэгдэх тоосжилт байх болно. Агаарын чанарын хяналт шинжилгээг мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагаар уг хөтөлбөрт тусгагдсан хугацаа, давтамжийн дагуу сонгосон байршилд болон түүний ойр орчимд хийлгүүлэх нь зүйтэй. Агаарын чанарын сорьц авах цэгүүдийн байршлыг дараах зурагт харуулав.



Зураг 2. Агаарын хяналт шинжилгээний цэг


3.2. Гадаргын усны хяналт шинжилгээ

Гадаргын усны шинжилгээг дулааны улиралд гол чөлөөтэй урсаж байгаа үед уурхайн карьераас доош урсгалын чиглэлд хийнэ. Дээж авах цэгийн байршлыг зургаас харна уу.

Эх үүсвэр дээрээс усны дээж авах ажлыг уурхайн БО-ны ажилтан гүйцэтгэж болох ба дараах зөвлөмжийн дагуу хийх шаардлагатай. Эсхүл мэргэжлийн байгууллагаар гэрээлэн хийлгэж болно. Дээжийг төсөл хэрэгжүүлэгч өөрсдөө зааврын дагуу зөв авсан тохиолдолд даруйхан мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораторит хүргэн шинжилгээг хийлгүүлнэ.

Дээж авахдаа доорх дарааллыг баримтална. Үүнд:

- Хар хуст гол дээр сонгосон дээж авах байршилыг доорх зургаас тодорхойлон баримжаалан очих, эсхүл байршил тодорхойлогч GPS ашиглан газарзүйн солбицолоор нь олж очно.
- Цэвэр усны 1.5л-ийн савыг 3 удаа тухайн голын усаар зайлж асгах, үүний дараа тухайн саваа голын ус руу дүрж дээжийг авна. Савыг дүүргэнэ.
- Дээж авсаны дараагаар савыг сайтар битүүмжилж гэрэл болон хэт дулаанаас хамгаалсан байдалтайгаар лаборатори руу хүргүүлнэ.
- Дээжийг илгээхийн өмнө дээжний хаяглалтыг хийж саван дээр нааж өгнө. Хаяглалтыг бичихдээ дараах зүйлсийг оруулна. Үүнд:
 - Гол горхины нэр
 - Дээж авсан газрын нэр
 - Дээж авсан цэгийн координат
 - Дээж авсан огноо
 - Аж ахуйн нэгжийн нэр



Зураг 3. Гадаргын усны хяналт шинжилгээний цэг


3.3. Газрын доорх усны хяналт шинжилгээ

Газрын доорх усанд чанарын болон усны түвшний хяналт шинжилгээг хийнэ. Чанарын хяналт шинжилгээг тусгай зөвшөөрлийн талбай дотор байгаа айлын унд ахуйд ашиглагдаж буй худаг, уурхайн ашиглалтын өрөмдмөл худгууд, баяжуулалтын үйл ажиллагаанаас гарсан нуурын усанд хийж гүйцэтгэнэ. Харин түвшний хяналт шинжилгээг уурхайн ашиглалтын худгууд болон хяналтын цооног, мөн талбай доторх айл өрхийн худгуудад явуулна. Усны түвшинг автоматаар хэмжигч төхөөрөмж эсхүл гар аргаар хэмжинэ.

Чанарыг хяналт шинжилгээг хийхдээ сонгогдсон байршлуудаас усны дээж авч мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораторит хүргэнэ. Дээж авахдаа доорх дарааллыг баримтална. Үүнд:

- Цэвэр усны 1.5л-ийн сав эсхүл дээжний зориулалтын полиэтилен савыг 3 удаа тухайн худгийн усаар зайлж асгасны дараагаар шинжилгээнд явуулах дээжийг авна. Дээжний савыг дүүргэнэ.
- Дээж авсаны дараагаар савыг сайтар битүүмжилж гэрэл болон хэт дулаанаас хамгаалсан байдалтайгаар лаборатори руу хүргүүлнэ.
- Дээжийг илгээхийн өмнө дээжний хаяглалтыг хийж саван дээр нааж өгнө. Хаяглалтыг бичихдээ дараах зүйлсийг оруулна. Үүнд:
 - Худгийн нэр /эх үүсвэрийн нэр/

- Дээж авсан газрын нэр
- Дээж авсан цэгийн координат
- Дээж авсан огноо
- Аж ахуйн нэгжийн нэр




Зураг 4. Газрын доорх усны хяналт шинжилгээний цэг

3.4. Хөрсний хяналт шинжилгээ

Хөрсний хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд, тэдгээрийн байршил, хугацаа давтамжийг ОХШХ-ийн хүснэгтэд харуулсан бөгөөд дээж авахдаа доорх дарааллыг баримтална. Үүнд:

- Дээж авахаар сонгосон талбайд (0-20) см-ийн гүнээс тус бүр (300-500) г хөрсийг хүрз, хусуур зэрэг багажийн аль нэгийг хэрэглэн дээжийг авна.
- Хөрсний гадарга, хөрсний зүсэлтийн фото зураг авна. Авахдаа тухайн зүсэлт хийсэн цэг дээр цаасан дээр тухайн цэгийн координат, мөн хаягласан ууттай дээжийг байршуулан авна.
- Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэл хийнэ
- Дээж авахдаа хаяглалтыг тодорхой бичнэ. /хөрсний гүн, өнгө, солбицол/
- Итгэмжлэгдсэн лабораторит хүргүүлэн задлан шинжилгээ хийлгэнэ.



Зураг 5. Хөрсний хяналт шинжилгээний цэг

3.5. Ургамлын хяналт шинжилгээ

Уурхай нь дотоод овоолгын төлөвлөлттэй явах тул биологийн нөхөн сэргээлтийг ч зэрэгцүүлэн явуулах боломжтой. Иймд нөхөн сэргээлт хийсэн талбайд болон төслийн талбайн ойр орчимд эрүүл нөлөөлөлд өртөөгүй талбайд ургамлан нөмрөгийн тархалт, бүрхэц, нягтшил зэргийг тодорхойлон геоботаникийн дэлгэрэнгүй бичиглэл хийж зориулалтын бланк дээр тэмдэглэл хийнэ. Бичиглэл хийсэн талбайн ургамлын төрөл зүйлийн тохиолдоцыг 1x1м, 10x10м хэмжээтэй талбайд хийж ургамлан бүлгэмдлийн хэв шинж, тусгагын бүрхэцийг тодорхойлно.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, 2023 он

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Баримтлах стандарт, арга, аргачлал
1.	Агаарын чанар					
	<ul style="list-style-type: none"> — Хүхэрлэг хий (SO₂) — Азотын давхар исэл (NO₂) — PM_{2.5} тоосонцор — PM₁₀ тоосонцор — TSP нийт тоос — Бусад хорт бодисын агууламж 	1. Уурхайн карьерийн салхины чиглэлийн доор-1 цэг 47°38'04.57"N 107°57'11.07"E 2. Хяналтын цэг-1 47°38'22.50"N 107°56'41.68"E Нийт -2 цэг	Жилд 2 цэгээс 2 удаа /5, 9 тус бүр 1 удаа / дээж авна.	98.0	392.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5885.2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага.
	<ul style="list-style-type: none"> — Дуу шуугиан 	3. Уурхайн карьер орчимд – 1 цэг Нийт -1 цэг	Уурхайн идэвхитэй үйл ажиллагааны саруудад, сард 2 удаа	Үйл ажиллагааны зардлаас		MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм, түвшний хэмжээ
2.	Хөрсний чанар					
	Хөрсний бохирдлын үзүүлэлтүүд (хүнд металл): <ul style="list-style-type: none"> — Хар тугалга — кадми — зэс — никель — кобальт — мангани — хром 	1. Засварын газар 47°38'49.94"N 107°56'27.20"E 2. Баяжуулах хэсэг 47°38'13.95"N 107°57'11.21"E 3. Овоолго 47°38'08.76"N 107°57'27.41"E 4. Хяналтын цэг	Жилд 2 удаа /5, 9 тус бүр 1 удаа дээж авна/	35.0	280.0	MNS 2305:1994 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 3298:1990 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

	— хүнцэл гэх мэт	47°38'24.82"N 107°57'15.96"E Нийт 4 цэг				
3.	Хөрсний элэгдэл, эвдрэл					
	Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд (Ялзмаг, урвалын орчин, карбонат, фосфор, кали, давсжилт, чулуужилт, хөрсний чийг, мехнаик бүрэлдэхүүн гэх мэт)	1. Шимт хөрсний овоолго 47°38'01.28"N 107°57'05.92"E 2. Хотхон орчмоос 47°38'55.05"N 107°56'27.94"E 3. Баяжуулах хэсэг 47°38'13.95"N 107°57'11.21"E Хяналтын цэг 47°38'24.82"N 107°57'15.96"E Нийт 4 цэг	Жилд 2 удаа /5, 9 тус бүр 1 удаа дээж авна/	30.0	240.0	MNS 2305:1994 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 3298:1990 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
4.	Усны чанар					
	Усны ерөнхий химийн үзүүлэлт — Ундны усны мэдрэхүйн үзүүлэлт — Ундны усны байгалийн гаралтай химийн найрлагын үзүүлэлт — Ундны усны ахуйн болон үйлдвэрлэлийн гаралтай бохирдлын химийн үзүүлэлт — Ундны усны хөдөө аж ахуйн үйл ажиллагааны гаралтай — Бичил амь судлалын аюулгүйн үзүүлэлт — Уссан хүчилтөрөгч O ₂ — Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч BXX ₅ — Химийн хэрэгцээт хүчилтөрөгч XXX	1. Уурхайн ашиглалтанд байгаа худагаас-1 цэг 47°38'49.17"N 107°55'47.60"E 2. Талбайн ойролцоох айлын унд ахуйн худгаас- 1 цэг 47°39'02.24"N 107°58'26.29"E Нийт 2 цэг	Жилд 2 цэгээс 3 удаа /5, 7, 9 тус бүр 1 удаа / дээж авна.	46.0	276.0	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 3935:1986 Ахуйн хэрэгцээ, ундны зориулалттай ус. Хээрийн шинжилгээний аргад тавих ерөнхий шаардлага MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт

	<p>Ус бохирдлын химийн үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> — Хар тугалга — кадми — зэс — никель — кобальт — мангани — хром — хүнцэл гэх мэт 	<p>3. Баяжуулах хэсгийн нуурын уснаас -1 цэг 47°38'13.45"N 107°57'13.40"E</p> <p>4. Уурхайн худаг ашиглалтанд буй худагаас-1 цэг 47°38'49.17"N 107°55'47.60"E</p> <p>5. Талбайн ойролцоох айлаас- 1 цэг 47°39'02.24"N 107°58'26.29"E</p> <p>Нийт – 3 цэг</p>	<p>Жилд 3 удаа /5, 7, 9 тус бүр 1 удаа / дээж авна.</p>	<p>35.0</p>	<p>140.0</p>	<p>MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ</p> <p>MNS ISO 5667-11:2000 Усны чанар. Дээж авах. 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж</p> <p>MNS ISO 5667-6:2001 Усны чанар. Дээж авах. 6-р бүлэг. Гол горхины уснаас дээж авах заавар</p>
<p>5.</p>	<p>Усны нөөц, горим</p>					
	<p>Газрын доорх усны түвшинд хяналт хийх</p>	<p>1. Уурхайн ашигалагдаж буй худгууд -3 цэг</p> <p>2. Талбай доторх айл өрхийн унд ахуйн худаг-3 цэг</p> <p>Нийт -6 цэг</p>	<p>Жилд 3 удаа (хавар, зун, намарт тус бүр 1 удаа)</p>	<p>Үйл ажиллагааны зардлаас</p>		
<p>6.</p>	<p>Ургамлын аймаг</p>					
	<p>Ургамлан нөмрөгийн тархалт, бүрхэц, нягтшил зэргийг тодорхойлох</p>	<p>1. Жил бүрийн биологийн нөхөн сэргээлт хийгдсэн талбай</p> <p>2. Төслийн талбайн ойр орчимд эрүүл нөлөөлөлд өртөөгүй талбай</p>	<p>Зуны улиралд жилд 1 удаа</p>	<p>270.0</p>	<p>270.0</p>	<p>Холбогдох аргачлалын дагуу</p>
<p>Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал – 1,598.0 мян.төг</p>						

ДӨРӨВ. БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар БОАЖЯ-д тайлан хүргүүлэх ба орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга нарт мөн хүргүүлнэ.

БОМТ-г танилцуулах хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /БОАЖЯ/	БОМТ-ний тайланг хүргүүлж танилцуулах	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	Жил бүрийн 12 дугаар сард багтааж	Цаашид анхаарах асуудал	БОАЖЯ
Эрдэнэ сумын Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч	БОМТ-ний тайланг танилцуулах	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тухай	Жилд 2-оос доошгүй удаа	Цаашид анхаарах асуудал	ЗДТГ
Эрдэнэ сумын Хушинга багийн ИНХ	БОМТ-ний тайланг танилцуулах, хэлэлцүүлэх	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тухай	Жил бүр	Цаашид анхаарах асуудал	Багийн ИНХ

ДҮГНЭЛТ

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчноо хамгаалах, нийгмийн хариуцлагын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Авдрант нэртэй газарт “Принципал инвестментс” ХХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Цагаан тугалганы ордыг ашиглах” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргааг доор харуулав.

Хүснэгт 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгтгэл

№	Хийгдэх ажил	Зардал /төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээ	9.513.900
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1.975.000
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3.000.000
4	Техник, биологийн нөхөн сэргээлтийн зардал	3.727.932
5	Дүйцүүлэн хамгаалах	5.100.000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1.268.000
7	Нийт зардал	24.584.832.0

Менежментийн зардлыг дээрх байдлаар 1 жилийн хугацаанд хийгдэх ажлаар бодож тооцоолон **24.584.832.0** төгрөгийг төлөвлөгөө гаргасан бөгөөд тухайн төслийн буюу “Цагаан

тугалганы ордыг ашиглах” төслийн хүрээнд үйл ажиллагаа явуулах явцдаа дээрх менежментийн төлөвлөгөөний зардлаас илүү зардал гаргах боломжтой гэж үзэж байгаа бөгөөд тухайн зардлыг “Принципал инвестэнтс” ХХК үйл ажиллагааны зардал болон байгууллагын дотоод зардлаар нөхөн зарцуулан гэж тооцлоо.

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас дараах саналуудыг 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулахаар өгсөн. Үүнд

1. Орон нутгийн болон улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын хамгаалалтын чадавх, менежментийг сайжруулах зорилгоор санхүүгийн туслалцаа үзүүлэх,
2. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг төлөвлөгөөнд тусгаж эхлүүлэх, БОАЖГазартай хамтран ажиллах,
3. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд булаг шандны эхийг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг тухайн бүс нутгийн малчидтай хамтран хийх
4. Уурхайн хүнсний хангамж, хэрэгцээг төслийн талбай орчмын малчид иргэдээс авах зэрэг саналуудыг өгснийг 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж өгсөн.